

Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэн стандартыг тогтоох тухай журмын 10 дугаар хавсралт

**Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр**

Төсвийн ерөнхийлөн захирагч: Аймгийн Засаг дарга

(Хуулийн 6.4.8, 6.8.1 заалтын хүрээнд)

Д/д	Шийдвэр гаргагч	Шийдвэрийн огноо	Шийдвэрийн дугаар	Төрөл/хөрөнгө зарцуулах, өр авлага үүсгэх	Шийдвэрийн хуулбар
1	Аймгийн Засаг дарга	2024.03.01	A/90	Хөрөнгө зарцуулах тухай	
2	Аймгийн Засаг дарга	2024.03.01	A/91	Хөрөнгө зарцуулах тухай	
3	Аймгийн Засаг дарга	2024.03.07	A/94	Хөрөнгө зарцуулах тухай	
4	Аймгийн Засаг дарга	2024.03.07	A/97	Хөрөнгө зарцуулах тухай	
5	Аймгийн Засаг дарга	2024.03.12	A/107	Хөрөнгө зарцуулах тухай	
6	Аймгийн Засаг дарга	2024.03.19	A/116	Дэмжлэг үзүүлэх тухай	
7	Аймгийн Засаг дарга	2024.03.20	A/119	Дэмжлэг үзүүлэх тухай	

Төрийн сангийн мэргэжилтэн: Б.Гантулга

Холбогдох утас: 88089938

И-мэйл хаяг: b.gantulga@khs.gov.mn



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 01 өдөр

Дугаар А/90

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.1, 2.1.4, аймгийн Онцгой комиссын 2024 оны 3 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2023 оны А/649 дүгээр захирамжийн хэрэгжилтийг хангах хүрээнд Цэцэрлэг, Цагаан-Уул сумдад зудын эрсдэлийн үнэлгээ хийх явцад байгууллагуудын машинд эвдрэл гэмтэл гарсан тул автомашины засварт зориулж зарцуулах хөрөнгийн задаргааг хавсралтаар баталсугай.

2. Туулах чадвар сайтай автомашины бэлэн байдлыг хангах, Эрсдэлийн үнэлгээ хийх явцад гарсан тээврийн хэрэгслийн сэлбэг авах зардалд шаардагдах нийт 10,685,000 (Арван сая зургаан зуун наян таван мянга) төгрөгийн зардлыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Оюунтуяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

Аймгийн Засаг даргын  
03 дугаар сарын 01-ны өдрийн  
захирамжийн хавсралт



### НӨӨЦ ХӨРӨНГӨӨС ЗАРЦУУЛАХ ЗАРДЛЫН ТООЦОО

№	Байгууллагын нэр	Зардлын утга	Хөрөнгийн хэмжээ
1	Цагдаагын газар	Сэлбэг хэрэгсэл, засварын зардал	6,000,000
2	Хүнс, хөдөө аж ахуйн газар	Сэлбэг хэрэгслийн үнэ	1,500,000
3	Хөвсгөл Эрчим Хүч ХХК	Сэлбэг хэрэгслийн үнэ	3,185,000
	Бүгд		10,685,000

-----oOo-----



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 01 өдөр

Дугаар А/91

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Засгийн газрын 2024 оны 62 дугаар тогтоол, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2024 оны 101 дүгээр тушаал, аймгийн иргэдийн Төлөөлөгчдын Хурлын 2023 оны 4 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2024 оны 7 дугаар хуралдааны шийдвэр, аймгийн Онцгой комиссын 2024 оны 3 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2024 оны 101 дүгээр тушаалын дагуу Хөвсгөл аймагт хуваарилагдсан 225 тн, тэжээлийн будааг тээвэрлэх зардал, будааг савлаж сумдад хүргэх, мөн "Дэлхийн Зөн Монгол" олон улсын байгууллагын "Дулаахан өвөлжье" аянд нэгдэхтэй холбоотой зардлын задаргааг хавсралтаар баталсугай.

2. Дээрх зардлын 38,187,500 (Гучин найман сая нэг зуун наян долоон мянга таван зуу) төгрөгийн зардлыг аймгийн Гамшгийн эрсдэлийг бууруулах зардлаас гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Оюунтуяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

671:010283

Аймгийн Засаг даргын 2  
03 дугаар сарын 01-ны өдрийн  
захирамжийн хавсралт



ГАМШГИЙН ЭРСДЭЛ БУУРУУЛАХ ЗАРДЛААС  
ЗАРЦУУЛАХ ЗАРДЛЫН ТООЦОО

№	Байгууллагын нэр	Зардлын утга	Хөрөнгийн хэмжээ
1	Иргэн Ц.Энхболд	Тээврийн зардал	19,687,500
2	Хүнс, хөдөө аж ахуйн газар	Буудай савлахтай холбоотой зардал	8,500,000
3	Дэлхийн Зөн Монгол байгууллага	“Дулаахан өвөлжье” аянд нэгдэх	10,000,000
	Бүгд		38,187,500

-----oO-----



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 07 өдөр

Дугаар А/94

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5, 2.1.6, 4.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 04 дүгээр тогтоол, аймгийн аймгийн Засаг даргын зөвлөлийн 2024 оны 7 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн нутаг дэвсгэрт өвөлжилт, хаваржилтийн нөхцөл байдал хүндэрсэн тул зудтай сумдад өвс тэжээл хүргэх, цасанд хаагдсан зам давааг сэргээх ажилд дайчлан ажиллуулах явцад эвдэрсэн Зэвсэгт хүчний 321 дүгээр тусгай салбарын автомашины засварын зардалд 1,750.000 (Нэг сая долоон зуун тавин мянга) төгрөгийг зарцуулсугай.
2. Батлагдсан зардлыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)- т зөвшөөрсүгэй.
3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Базар)- д даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

6713010296



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 07 өдөр

Дугаар А/07

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн ээлжит XXIII хуралдааны 04 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 7 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Бүгд Найрамдах Солонгос Улсад болох олон улсын хамтарсан бэлтгэлд явах Мөрөн сумын иргэн марафон гүйлтийн тамирчин Ш.Түмэнбаярын замын зардалд 500,000 (таван зуун мянга) төгрөг, Цагааннуур сумын иргэн Монголын боксын холбооны гишүүн боксын спортын тамирчин С.Биндэрьяагийн “Лос-Анжелес 2028” зуны олимпод оролцох бэлтгэлийн зардалд 500,000 (таван зуун мянга) төгрөг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, Мөрөн сумын Засаг даргын Тамгын газраас санаачлан зохион байгуулсан “Бид ирээдүйн эзэд” сургалтын зардалд 500,000 (таван зуун мянга) төгрөг, Бүгд Найрамдах Хятад ард Улсад болох Олон Улсын Таеквондогийн тэмцээнд оролцох Мөрөн сумын Эрдмийн далай цогцолбор сургуулийн сурагч О.Амаржаргалын замын зардалд 500,000 (таван зуун мянга) төгрөгийн дэмжлэгийг тус тус олгосугай.

2.Дээрх зардлын 2,000.000 (хоёр сая ) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх), нягтлан бодогч (Э.Анхцэцэг)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Б.Батбилгүүн)-т даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

6712010299



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 12 өдөр

Дугаар А/107

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Засгийн газрын 2024 оны 62 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдын Хурлын 2023 оны 4 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2024 оны 8 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Цас их орж өвөлжилт хүндэрсэн сумдын малчдад хүнсний тусламжаар олгох 55 тн Цагаан будааг Улаанбаатар хотоос аймгийн төв хүртэл тээвэрлэх зардалд 3.000.000 (Гурван сая) төгрөг, Рашаант сумын төвөөр урсдаг Цэнгэлийн голд их хэмжээний халиа үүсч шар усны үет авсан тул далан барьж гудамж хороолол айл өрхийн шар уснаас хамгаалах, усны ургалыг боож зогсоох ажлын шатахууны болон бусад шаардлагатай зардалд 5.000.000 (Таван сая) төгрөгийг тус тус зарцуулсугай.

2.Дээрх зардлын 8.000.000 (Найман сая) төгрөгийг аймгийн Гамшгийн эрсдэлийг бууруулах зардлаас, гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Оюунтуяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

671010336





МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 19 өдөр

Дугаар А/116

Мөрөн сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3, 1 дэх хэсгийн 3, 15 дугаар зүйлийн 15.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4, 2.1.6, 4.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 01-ний 04 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2024 оны 08 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн шалтгааны улмаас эмчлүүлэхэд санхүүгийн дэмжлэг хүссэн иргэн О.Энхбаярт 1.000,000 (Нэг сая) төгрөг, Дорнод аймагт зохион байгуулагдах Волейболын Идэрчүүдийн Улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох баг тамирчдын хувцасны зардалд 3.600,000 (Гурван сая зургаан зуун мянга ) төгрөг, санхүүгийн дэмжлэг хүссэн Мөрөн сумын иргэн Ч.Дуламжавт 1.000,000 (Нэг сая) төгрөг, "Хөх сувд" даамын клубын дасгалжуулагч О.Отгонбатад тэмцээний зардалд 1,000.000 (Нэг сая) төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүлсүгэй.

2. Дээрх зардлын 6.600,000 (Зургаан сая зургаан зуун мянган ) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ



671010338



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 20 өдөр

Дугаар А/119

Мөрөн сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, 15 дугаар зүйлийн 1, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 2.1.6, 4.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 04 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2024 оны 09 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Төв музейн захирал Х.Рагчаа нь Монгол Улсад орчин цагийн музей байгуулагдсаны 100 жилийн ойн хүрээнд БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс Хонконгт болох “Museum summit-2024” хөтөлбөрийн арга хэмжээнд оролцох байр, хоолны зардалд 3.000.000 (Гурван сая) төгрөгийн дэмжлэг тус тус үзүүлсүгэй.
2. Дээрх дэмжлэгийн 3.000.000 (Гурван сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т зөвшөөрсүгэй.
3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (Б.Батбилгүүн)-т үүрэг болгосугай.

ОРЛОГЧ



М.ХУЯГБААТАР

6710010352